БАТЛАВ.
"ТОСОН ЭНЕРЖИ"ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ..... /М.ТҮВШИНБАТ/

№А39/25

2025.04.21 Завхан аймаг

1. **Хэрэглэгчийн нэр:** Өргөтгөл шинэчлэлтийн ажил
2. **Хэрэглэгчийн байршил:** Одоо байгаа болон шинэ хэрэглэгчид
3. **Дулааны хэрэглээ:** Халаалт 24МВт
   Эхний үе шат 15 МВ
4. **Холболтын цэг:** Станцын гаргалгаанаас
5. **Сүлжээний усны гарах температур**: 120^0С
   Буцах температур: 70^0С
6. Завхан аймгийн гадна агаарын тооцоот температур -39^0С
7. Шугам сүлжээний зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, хийлгэх явцад дор дурдсан техникийн даалгаврыг зураг төсөлд тусгуулах.
   7.1 Шугамын трассыг одоо байгаа трассаар гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд трассыг өөрчлөх.
   7.2 Төлөвлөж буй барилгын дулааны хэрэглээг олгогдсон техникийн нөхцлийн ачааллаас хэтрүүлэхгүйгээр зураг төсөлд тусгах.
   7.3 Дулааны шугам сүлжээ авто зам болон нийтийн эзэмшлийн талбай доогуур огтлох нөхцөлд нэвтрэх сувагтай байхаар төлөвлөж зураг төсөвт тусгах.
   7.4 Дулааны шугамыг барихдаа трассын дагуух тохижилт, нөхөн сэргээх ажлын зардлыг төсөвт тусгах, нөхөн сэргээх.
   7.5 Гадна дулаан ханагамжийн системын шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах.
   7.6 Дулаан хангамжийн гэрээг хангагч байгууллагатай хийж, үйлчилгээг хүлээн авсан хугацаанаас эхлэн төлбөрийг төлөх.
   7.7 Дулааны шугам, тоноглол, хянах хэмжих хэрэгсэл, дулаалга зэргийг сонгох, угсрахдаа холбогдох БНбД, ТАД, ААД-ийг чанд мөрдөж ажиллах шаардлагатай.
8. Барилгын ажил эхлэхээс өмнө "ТОСОН ЭНЕРЖИ"ХХК -тай гадна дулаан хангамжийн ажлын зургийг зөвшилцөн баталгаажуулна.
9. Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйл, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн 1, 3 дахь заалтуудыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаас хамгаалалтын зурвасын зай хэмжээг хангаж барилгыг төлөвлөх.
10. Барилга угсралтын ажил, гадна шугам сүлжээний ажлыг ил далд ажлын акт үйлдэж баталгаажуулж байх, зураг төсөлд өөрчлөлт орох тохиолдолд зохиогчтой зөвшилцөх.
11. Засгийн газрын 2001 оны 12-р сарын 05-ны өдрийн 261 тоот тогтоолоор батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний хууль", "Байгууллага хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийн холбогдох заалтуудыг тус тус хэрэгжүүлэх.
12. Энэхүү техникийн нөхцөл 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
13. Төвлөрсөн шугам сүлжээнд огтлол хийх, хэрэглэгч холбох хугацааг жил бүрийн 5-р сарын 01-ээс 09-р сарын 01-ны хооронд хийх болохыг анхааруулъя.
14. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж хангагч байгууллагад өгөх.